



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

"Бадрангийх" ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгож,
төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэхийг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт"-ын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Бадрангийх" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг "Бадрангийх" ХЗХ /О.Одгэрэл/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000743-4